# Арлингтоны Улсын Сургуулиуд
# Онлайнаар сурагч бүртгүүлэхийг шалгах жагсаалт

**Арлингтоны улсын сургуульд сурагч бүртгүүлэхийн тулд эцэг эх/асран хамгаалагч дараахыг өгөх ёстой:**

## 1. Арлингтон каунтид оршин суугчийн баталгаа

**Хэрэв сурагч эцэг эх/хууль ёсны асран хамгаалагч нь эзэмшдэг эсвэл түрээсэлдэг үл хөдлөх хөрөнгөд амьдардаг бол:**

Дараах бичиг баримтын **НЭГИЙГ** өгсөн байх ёстой:

- ☐ Сурагчийн эцэг эх эсвэл хууль ёсны асран хамгаалагчид нь Арлингтон дахь үл хөдлөх хөрөнгийг эзэмшдэг болохыг харуулсан **гэрчилгээ**.
- ☐ Түрээслэгч ба түрээслүүлэгчийн гарын үсэг зурсан **одоогийн түрээсийн гэрээ**.
- ☐ Шинээр худалдаж аваад гэрчилгээг бүртгүүлээгүй байгаа бол **тохиролцооны бичиг баримт**.

**Хэрэв сурагч ба түүний эцэг эх/хууль ёсны асран хамгаалагч нь өөр хэн нэгний орон сууц, байранд (хамтын орон сууц, байр) амьдардаг бол:**

Дараах **ГУРВАН** бичиг баримтыг өгсөн байх ёстой:

- ☐ **Маягт А** – Эцэг эх/хууль ёсны асран хамгаалагчийн оршин суугчийн тодорхойлолт
- ☐ **Маягт Б** – Арлингтоны оршин суугчийн тодорхойлолтын мэдүүлэг
- ☐ Түрээс эзэмшигчийн **одоогийн түрээсийн гэрээ** эсвэл **гэрийн эзний гэрээ** эсвэл шинээр худалдаж аваад гэрчилгээг бүртгүүлээгүй байгаа газар бол **тохиролцооны бичиг баримт**.

**МӨН Арлингтон каунтид оршин суудгийг дэмжих дараах ангиллын зүйлсээс ХОЁР бичиг баримтыг өгнө**

Эцэг эх/асран хамгаалагчийн нэр ба одоогийн Арлингтоны хаягийг багтаасан дараах дэмжих хоёр бичиг баримтыг сурагчийн сургуульд элсүүлсэн өдрөөс 30 өдрийн дотор өгсөн байх ёстой:

- Одоогийн холбооны, мужийн эсвэл үл хөдлөх хөрөнгийн татварын буцаалт
- Одоогийн цалингийн хуудас эсвэл суутгалын тайлан
- Одоогийн хэрэглээний төлбөрийн хуудас (*цахилгаан, хий, интернет эсвэл ус*)
- АНУ-ын холбооны, мужийн эсвэл орон нутгийн засаг захиргаанаас авч байгаа санхүүгийн тусламжийн бичиг баримт
- Виржиниагийн хүчинтэй жолооны үнэмлэх эсвэл үнэмлэх
- Тээврийн хэрэгслийн бүртгэл

## 2. Сурагчийн нас ба хууль ёсны нэрийн баталгаа

- ☐ **Төрсний гэрчилгээний эх хувь** – Хэрэв төрсний гэрчилгээний эх хувь нь англи хэл дээр биш бол албан ёсны орчуулга шаардлагатай. *Хэрэв төрсний гэрчилгээний эх хувийг өгөх боломжгүй бол,* Сурагчийн биеийн байцаалт ба насыг батлах баримтыг *өгнө. Энэ баримт нь 30 өдрийн турш хүчинтэй бөгөөд хүүхдийн паспорт зэрэг нэмэлт дэмжих бичиг баримтыг шаардана.*

## 3. Эцэг эхийн биеийн байцаалт ба сурагчтай хамаарах байдлын баталгаа

- ☐ Засгийн газраас олгосон зураг бүхий хүчинтэй биеийн байцаалт (*Жолооны үнэмлэх эсвэл паспорт*)

## 4. Өмнөх боловсролын хөтөлбөрийн бичиг баримт

**Бүртгүүлэхэд шаардахгүй, гэхдээ байгаа бол өгнө:**

- ☐ Академик бүртгэл эсвэл албан ёсны дүнгийн хуудас. Хэрэв эдгээр бичиг баримт англи хэл дээр биш бол албан ёсны орчуулга шаардлагатай.
- ☐ Боломжтой бол Хувь хүний боловсролын хөтөлбөр (IEP), 504 төлөвлөгөө, англи хэл суралцагчийн бүртгэл эсвэл Гоц хүүхдийн бүртгэл зэргийг өгнө.

## 5. Эрүүл мэндийн бүртгэл

**Бүртгүүлэхэд шаардахгүй, гэхдээ дараахыг сурагч сургуульд явж эхлэхээс өмнө сургуульд өгсөн байх ёстой:**

- ☐ Дархлаажуулалтын бүртгэл (Цэцэрлэгийн өмнөх – 12-р анги)
- ☐ Сүрьеэгийн шинжилгээ эсвэл үзлэг, сургууль эхлэхээс өмнө 12 сарын дотор хийлгэсэн байх (Цэцэрлэгийн өмнөх – 12-р анги)
- ☐ Биеийн үзлэг, сургууль эхлэхээс өмнө 12 сарын дотор хийлгэсэн байх (Цэцэрлэгийн өмнөх – 5-р анги)

Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол https://www.apsva.us/registration/ хуудсанд зочилно уу. Бүртгэлийн уулзалт товлох бол хөршийн сургуультайгаа холбоо барьж, Угтах төвийн 703.228.8000 дугаараар ярих эсвэл registration@apsva.us руу э-мэйл бичнэ үү.